



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 5/72

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05/7754 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стратеги төлөвлөлтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн Эмнэлгийн хэрэгслийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Л.Намхайноровыг тус газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацааг 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс дуусгавар болгосугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн "Түр орлон гүйцэтгүүлэх тухай" Б/15 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Батбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.ОЧИРБАТ

142250535